



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ХАРХОРИН
ХК-ИЙН**

**2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

Агуулга:

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:.....	2
2. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн болон МХБирж дээрх үндсэн мэдээлэл:.....	2
3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:.....	3
4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:	3
5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:	4
6. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулга:.....	5
7. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:.....	5
8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт (2018 оны жилийн эцсийн байдлаар).....	6
9. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл.....	8
10. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл.....	8
11. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр:	15
12. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл болон тус зөвлөлөөс гаргасан шийдвэрүүдийн тухай	16
13. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл	17

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Хархорин ХК

Хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ-толгой баг, Усжуулахын контор

Утас: 70327890, 90999919

Факс: 70151955

Электрон хаяг: assistant.kh.kh@gmail.com

2. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн болон МХБирж дээрх үндсэн мэдээлэл:

Д.д	Үзүүлэлт	Утга	Тайлбар
1	Оноосон нэр, хариуцлагын хэлбэр	Хархорин ХК	Нээлттэй хувьцаат компани
2	Зохион байгуулалтын хэлбэр	Хувьцаат компани	МХБ-д бүртгэлтэй, симбол: ННН, дугаар: 179
3	Регистрийн дугаар	2015471	
4	Улсын бүртгэлийн дугаар	1010001006	
5	Нийт гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг	539,515	
6	Нэрлэсэн үнэ, төг	100	
7	Хувь нийлүүлсэн хөрөнгө, төг (улсын бүртгэлд тусгагдсан)	53,951,500	Компанийн тухай хуулийн дагуу
8	Нэгж хувьцааны ханш, төг	1,750	2019.03.29 байдлаар
10	Том хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл	5%-аас дээш хувьцаа эзэмшигчид	Төвлөрлийн хувь: Нийт 2 хувьцаа эзэмшигчид 479,294 (88.84%)
10.1	С.Пүрэв	70.00%	
10.2	Селус Номадс ХХК	18.84%	
11	Үүсгэн байгуулагдсан огноо	1996.04.29	
12	МХБ-д бүртгүүлсэн огноо	1992.11.05	mse.mn
13	Компанийн албан ёсны хаяг	Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00	
14	Утас	70327890, 70151955	
15	Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх захирал Р.Саранцэцэг	
16	ТУЗ-ийн бүрэлдэхүүн		
16.1	ТУЗ-ийн ердийн гишүүд	П.Бишрэл	ТУЗ-ийн Дарга
		П.Учрал	ТУЗ-ийн ердийн гишүүн

		О.Төмөрбаатар	Цалин, урамшууллын хорооны дарга
		Л.Хосбаяр	Аудитын хорооны гишүүн
		Ц.Энх-Амгалан	Аудитын хорооны гишүүн
		Ж.Энхтөр	Нэр дэвшүүлэх хорооны дарга
16.2	ТУЗ-ийн хараат бус гишүүд	Б.Амарсанаа	Нэр дэвшүүлэх болон Цалин, урамшуулалын хороодын гишүүн
		С.Амгалан	Аудитын болон Цалин, урамшуулалын хороодын гишүүн
		Б.Бүрэн	Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
16.3	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга	Б.Ганбат	Утас: 99993800
17	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл (улсын бүртгэлд тусгагдсан)	Чацаргана тариалах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх	
		Үр тариа, малын тэжээл тариалах	
		Аялал жуулчлалын үйл ажиллагаа	
18	Одоогийн ажилтан ажиллагсдын тоо	194	

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Үнэт цаас гаргагчийн зорилго: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт тэргүүлэгч, чацаргана тариалагч, чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж болох.

Үйл ажиллагааны стратеги: “Хархорин” ХК нь Монгол Улсад төдийгүй дэлхийд томоохонд орох нийт 3,000 гаруй га талбай бүхий чацарганы “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнээс 2007 – 2018 онд нийт 600 гаруй га талбайд чацаргана тариалаад байгаа. Цаашид “Хархорин” ХК нь дараах үндсэн 2 чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй:

- 1) Дотоод гадаадын зах зээлд стандартын шаардлага хангасан чацарганы жимс нийлүүлэх бааз, суурь бий болгох,
- 2) Чацарганы тос гаргах орчин үеийн техник технологи бүхий үйлдвэр байгуулах.

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

Тус “Хархорин” ХК нь Монгол Улсын эртний нийслэл Хархорин хот, одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэтолгой багийн нутаг дэвсгэрт байрлаж байна. Хархорин сум нь Улаанбаатар хотоос баруун тийш 360 км, Өвөрхангай аймгаас зүүн хойш 130 км зайд оршдог.

Хархорин ХК нь анх 1956 онд БНМАУ-ын Засгийн газрын 100% хөрөнгө оруулалтаар Хархорин сум САА нэртэйгээр газар тариалан, мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн түүхтэй Монголын томоохон САА нэг юм. 1990 онд Монгол оронд Ардчилсан хувьсгал гарч ирсэнээр 1992 онд тус САА нь Хархорин ХК нэртэйгээр төрийн өмч хувийн өмчид шилжин 70% төр, 30% тухайн нутгийн ард иргэдэд өмчлөн холимог системээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 1992 оноос тус компанийн хэвийн ажиллагаа доголдож 2007 онд өмч хувьчлал буюу нээлттэй тендэр зарлан 100%, хувийн өмчид шилжсэн. Шилжсэн цагаас хойш тус компани нь өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн Монгол Улсын засгийн газраас баталсан “Чацаргана”, “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд, чацаргана үржүүлэх, тариалах чиглэлээр нийт 100 гаруй ажилтан албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь Ерөнхий агрономич Л.Бямбасүрэнгээр ахлуулсан 4 бригад, бригадыг ахалсан мэргэжлийн 4 агрономичтойгоор агроүйлдвэрлэл явуулж байна. Компанийн эзэмшлийн газар нутгийн хувьд 4000 гаруй га талбай, Орхон голоос эх авсан усалтын 13 м сувагтай 2007 оноос эдүүгээ нийт 600 гаруй га талбайд чацарганы жимст цэцэрлэг байгуулах ажлыг амжилттай байгуулан ажиллаж байна. Мөн 2014 он ОХУ-аас гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө, алим гэх мэт төрлийн жимслэг ургамлыг нутагшуулах ажлыг зохион байгуулж байна.

“Хархорин” ХК нь Монгол Улсад хамгийн томд орох таримал чацарганы талбайтай бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажилласан тохиолдолд жилд нийт 2,000 гаруй тонн чацарганы жимс хураан авч дотоодын чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх хүчин чадалтай.

Монголын Чацарганы холбооноос авсан мэдээллээр одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 40 гаруй том жижиг чацаргана боловсруулах үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрийн нийт хүчин чадлын хэмжээ нь жилд 5,000 орчин тонн түүхий чацаргана боловсруулах боломжтой. Үүнээс үзвэл “Хархорин” ХК нь дангаараа Монгол Улсын чацаргана боловсруулах үйлдвэрүүдийн нэг жилийн түүхий эдийн хэрэгцээний 40%-ийг хангах бололцоотой.

5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:

Тайлант хугацаанд “Хархорин” ХК-ийн бараа бүтээгдэхүүний гол зах зээл болох жимс, жимсгэнэ, тэр дундаа чацарганы дотоод болон гадаад зах зээлд томоохон өөрчлөлт гараагүй болно.

2018 онд компани нь 500 гаруй тонн ургац хураан авахаар төлөвлөж байсан боловч цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан төлөвлөсөн ургацаа хурааж чадаагүй. Энэ нь 2018 оны зун жимс ургах үед бороо хур багатай байсан, харин жимс боловсорсон үед буюу зуны сүүл үед бороо хур ихтэй байсантай холбоотой юм. Түүнчлэн хүн хүчний дутагдалтай холбоотойгоор компани нь 2018 оны 9-р сард хангалттай хэмжээний жимс хурааж чадаагүй,

талбай дээр ихээхэн хэмжээний жимс үлдсэн. Гэвч зуны сүүл үед бороо ихтэй байснаас үүдэн эдгээр жимсний ихэнх нь хорчийж үйлдвэрийн шаардлага хангахгүй болсон тул өвлийн саруудад цохиж хураах боломжгүй байсан.

6. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулга:

Н.Бишрэл	ТУЗ-ийн Дарга
Л.Хосбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн
О.Төмөрбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин, урамшууллын хорооны дарга
Ц.Энх-Амгалан	ТУЗ-ийн ердийн гишүүн, Аудитын хорооны гишүүн
Ж.Энхтөр	ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга
П.Учрал	ТУЗ-ийн ердийн гишүүн
Б.Амарсанаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын болон Цалин, урамшуулалын хороодын гишүүн
С.Амгалан	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
Б.Бүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх болон Цалин, урамшууллын хороодын гишүүн
Р.Саранцэцэг	Гүйцэтгэх захирал
Б.Ганбат	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Д.Дашмаа	Ерөнхий нягтлан бодогч

7. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

Д.д	Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Эзэмшиж байгаа хувьцааны тоо	Эзлэх хувь
1	Сүрэнжавын Пүрэв	377,660	70.0%
2	Селус Номадс ХХК	101,634	18.8%

8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт (2018 оны жилийн эцсийн байдлаар)

Үнэт цаас гаргагч нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2018.01.01-с 2018.12.31-ний тайлант хугацаанд өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. Хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид нь “Хархорин” ХК-ийн 2018 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн тайлантай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

“Хархорин” ХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу нийт хөрөнгө 8,279,839,0 мян.төг байсан бол 2018 оны 12-р сарын 31-ны байдлаар 7,721.961.1 мян төгрөг болж буурсан.

2018 оны жилийн эцсийн тайлангаар эргэлтийн хөрөнгийн хэмжээ 4,991,329.0 мян. төг, эргэлтийн бус хөрөнгийн дүн элэгдэл хассан дүнгээр 2,730,632.1 мянган төгрөг, үүнээс биологийн хөрөнгө 1,082,788.3 мян.төг байна.

2018 оны жилийн эцсээр мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 1,896.8 мян.төг, авлагын нийт дүн 1,171,919.3 мян.төг, бараа материал нийт 425,493.5 мян.төг, дуусаагүй үйлдвэрлэл 2,095,101.9 мян.төг, бусад санхүүгийн хөрөнгө 1,296,917.6 мян.төг байна.

Урт болон богино хугацаат өр төлбөр: 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу “Хархорин” ХК нь нийт 673,379.9 мян.төг-ийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй, богино хугацаат өр төлбөр 7,601,810.7 мян.төг, нийт 8,275,190.7 мян.төг-ийн өр төлбөртэй гэж гарсан.

Үр дүнгийн тооцоо

Тайлант хугацаанд: Борлуулалтын нийт орлого:	1,362,445.3 мян.төг;
Борлуулалтын өртөг:	1,336,366.8 мян.төг;
Борлуулалтын ашиг:	26,078.5 мян.төг;
Үйл ажиллагааны бус орлого:	90,575.0 мян.төг;
Ерөнхий ба удирдлагын зардал:	178,914.7 мян.төг;
Бусад зардал:	48,668.5 мян.төг

болж тайлант үеийн цэвэр алдагдал 110,929.7 мян.төг болсон.

“Хархорин” ХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн тухай

Компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын компани болох “Улиастай Ван Аудит” ХХК аудит хийсэн болно. Аудитын дүгнэлтийг дараах хуудаснаас үзнэ үү:



2019 оны 2 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 61/19

Улаанбаатар хот.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**“ХАРХОРИН” ХК-ийн
УДИРДЛАГАД**

Бид “ХАРХОРИН” ХК ийн (цаашид “Компани” гэх) 2018 оны 12 дугаар сарын 31-ны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайлангай холбоотой удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, тожлуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэл суурилан сонгосон бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцоололыг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигдах ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт найдаж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэг өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Бусад хууль тогтоомж, захиууллахын шаардлагын талаарх тайлан

Түүнчлэн, санхүүгийн тайлан бэлтгэхдөө Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Санхүүгийн тайланг бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн журам, заавартай нийцж байна.

“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

Чингэлтэй дүүрэг, 3-р хороо
Эхэтэймийн өргөн чөлөө
CANON тос, 6 дугаар, 602 тосон

УЛИАСТАЙ
ВАН-АУДИТ ХХК
Page: 02

Утас: 70157405, 99097405, 96696399
Мэйл хаяг: uliastai.van.audit@ubaudit.mn
Вэб хуудас: ubaudit.mn
Улаанбаатар Монгол улс

8.3. Татварын тайлангийн тухай (2018 оны жилийн эцсийн байдлаар):

“Хархорин” ХК нь 2018 оны жилийн эцсийн татварын тайлангаа Монгол улсын Татварын багц хууль, тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд гаргаж цахимаар харъяа татварын байгууллагад илгээж баталгаажуулсан болно.

9. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл

Тайлант хугацаанд “Хархорин” ХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох дараах хэлцлийг байгуулсан болно:

“Хархорин чацаргана” ХХК нь УБ хотын банкнаас нийт 1.16 хүртэл хэмжээний эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг зээл хэлбэрээр авахаар болсон бөгөөд “Хархорин” ХК нь тус зээлд батлан даалт гаргаж, УБ хотын банкинд барьцаанд байгаа өөрийн эзэмшлийн газар болон үл хөдлөх эд хөрөнгөнүүдийг давхар барьцаалахаар болсон юм. Энэхүү хэлцэл нь Компанийн тухай хуулийн дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох бөгөөд тус шийдвэрийг гаргахаар 2018 оны 3-р сарын 21-ний өдөр хуралдсан ТУЗ-ийн хуралд нийт 9 гишүүнээс 8 гишүүн оролцсон бөгөөд Компанийн тухай хуулийн 92-р зүйлийг баримлан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргасан болно.

10. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл

“Хархорин” ХК нь 2018 онд 500 тонн чацарганы ургац хураан авах төлөвлөгөө гарган ажилласан.

2018 оны 1-р сард байгууллагынхаа 2 ажилтныг ХАБЭА-н ажилтнаар сургаж мэргэшүүлэн сертификат олгосон.

2018 оны 06 сард Олон улсын нэгдсэн стандартчилалд багтахад эхний ээлжинд шаардагддаг зүйл болох GAP-ийн эхний шалгаруулалтанд тэнцсэн.

Мөн 5,6-р саруудад нийт ажилчдыг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх үүднээс Компанийн мэргэжилтнүүд болон Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Хархорин сумын Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын Ерөнхий газруудтай хамтран ажиллах гэрээ байгуулан сургалт, семинар зохион байгуулсан.

2018 оны 5-р сард Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын ээлжит шалгалт, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэсийн ээлжит шалгалтуудыг сайн үнэлгээтэй өгсөн.

2018 оны 03 сараас эхлэн усалгааны суваг шуудууны тоног төхөөрөмжийг засаж сэлбэх, өөрөө явдаг болон дүүжин, чиргүүлэн машин техник, тоног, төхөөрөмжүүдийг өвлийн тэг зогсолтоос гаргахаар усалгааны бригад, засварын газрын жолооч, механикжуулагчидыг ажилд нь оруулан засварын ажлуудыг хийлгэсэн.

Компанийн газар тариалангийн болон жимст цэцэрлэгийн талбайн ажил 2018 оны 4 сараас эхлэн одоог хүртэл гүйцэтгэл сайтай явагдаж байна.

5-р сард ХААЯ-ны ТЭДС-гаас энэ хавар авсан “Алтайское Румянное” сортын бэсрэг алимны 100 ширхэг, “Чемальская синяя”, “Жёлтая хопта” гэсэн хоёр сортын чавганы 496 ширхэг суулгацуудыг худалдан авч тарьсан.

2018 оны 5 сараас эхлэн чацаргана, хайлаас, шар хуайс болон бусад модны суулгац гаргаж эхэлсэн. Жилийн эцсийн байдлаар гадны байгууллага хувь хүмүүст 115,610 ширхэг чацарганы, 347 ширхэг хайлаасны, 263 ширхэг үхрийн нүдний, 98 ширхэг улиасны, 10 ширхэг шар хуайсны, 188 ширхэг бөөрөлзгөний, 31 ширхэг далан хальсны, 39 ширхэг гүзээлзгэний, 15 ширхэг моносны, 6 ширхэг улаалзганы 3 ширхэг нохойн хошууны, суулгацуудыг зарж борлуулсан.

Чацарганы суулгацыг гадаад улс орнуудруу нийлүүлэх талаар сургалт, судалгаа явуулж БНАСАУ-д 20,000-30,000 ширхэг чацарганы суулгац нийлүүлэхээр тохиролцож тариалалт хийх газарт нь 1 агрономчоо явуулан сургалт хийлгэсэн.

2018 оны 07 сараас чацаргана болон бусад жимсний модны тарилт хийсэн.

Мөн тус сард гүзээлзгэнэ 77,9 кг, бөөрөлзгөнө 99 кг жимс хураан авсан.

8-р сарын 25-с эхлэн чацаргана жимсний хураалт эхэлж 2018 оны жилийн эцсийн байдлаар 178,932,8 жимс хураан авсан. Жимс хураалтанд манай компанийн үндсэн хүн хүчээ гадна хамтран ажилладаг байгууллагууд болох ШШГА 423-р ангиас 55-н хүн хүч 1 сарын хугацаатай гэрээ байгуулан ажилласан. Мөн Шинэ монгол ахлах сургуулиас 120 сурагч багш нарын хамт, Өвөрхангай аймгийн Зэвсэгт хүчний 256-р ангиас 21 цэрэг тус тус 14 хоногийн хугацаатй ирж жимс хураалцсан.

Мөн тус онд МАА-д 9 толгой адуу шинээр авсан. нийт дүнгээрээ бог мал 426 толгой (364 хонь, 62 ямаа), бод мал 46 толгой (9 адуу, 37 үхэр) болон өсч мал сүргийн тоо толгой нэмэгдэж байна.

2018 оны 12 сард “Хархорин” ХК-ийн жилийн эцсийн тооллого хийгдэж тайлан баланс хугацаандаа хийгдсэн болно.

Гүйцэтгэх захирлын хувьд компанийг өдөр тутмын шуурхай удирдлагаар байнга ханган, тулгамдсан асуудлуудыг богино хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.

2018 онд “Хархорин” ХК-ийн

Чацарганы жимст ба эх цэцэрлэгийн талбайд хийгдсэн ажлын тайлан

2018 оны 04 сарын 2-ны өдөр жимст цэцэрлэг хариуцсан цэцэрлэгчдийн хүчээр сувгийн цэвэрлэгээг хийж эхэлснээр энэ жилийн жимст цэцэрлэгийн талбайн ажил эхлэсэн. Суваг цэвэрлэгээний ажил 4-р сарын 21-ний өдөр хүртэл буюу нийтдээ 13 хоног үргэлжилсэн. Энэ ажилд 1-р бригадын 90,5 хүн/өдөр хүчээр 202,76 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 9 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс 56 м³ сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан. 2-р бригадын 112 хүн/өдөр хүчээр 259,54 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 13 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс 78,7 м³ сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан. 3-р бригадын 68 хүн/өдөр хүчээр 110,2 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 2 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс 12 м³ сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан. 4-р бригадын 89 хүн/өдөр хүчээр 134,86 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 1 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс 6 м³ сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан. Нийт дүнгээрээ компаний цэцэрлэгчидийн 359,5 хүн/өдөр хүчээр 707,36 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 25 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс 152,7 м³ сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан.

4-р сарын 22-ны өдөр сувгаар Орхон голын усыг урсгаж эхлэсэн ба хоёр өдөр сувгийн усыг урсгаж цэвэршүүлээд мөн хоёр хоногт усалгааны системээ усаар угааж цэвэрлээд системээ дүүргээд, 4-р сарын 26-ны өдрөөс эхлэн талбайг услах боломжтой болгоод хүлэмжнээс гаргасан тарьцыг хайрцагт тариалж эхлэсэн.

4-р сарын 21 – 23-ны хооронд бойжуулгын талбайд хүлэмжнээс гаргах тарьцыг тариалах хайрцаг хийх ажилд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчийг ашигласан. Энэ ажилд 1-р бригадын 15,8 хүн/өдөр хүчээр 102,3 хайрцагийг, 2-р бригадын 17,5 хүн/өдөр хүчээр 116,6 хайрцагийг, 3-р бригадын 13,3 хүн/өдөр хүчээр 62 хайрцагийг, 4-р бригадын 17 хүн/өдөр хүчээр 112 хайрцагийг буюу нийтдээ 63,6 хүн/өдөр хүчээр 393 хайрцагийг шинээр хийсэн.

4-р сарын 25 – 30-ны хооронд 2017 онд ногоон мөчир тариалсан хүлэмжнээс тарьц гараар ухаж гаргасан ба энэ ажилд 1-р бригадын 50,1 хүн/өдөр хүч зарцуулан хүлэмжний 845,2 нуруунаас 140615 ширхэг тарьцыг чацарганы ногоон мөчир тариалсан 20 хүлэмжнээс ухаж гарган тариалалт хийж буй бригадуудад нийлүүлж тариалалт хийлгэсэн. 2-р бригадын 57 хүн/өдөр хүч зарцуулан хүлэмжний 928,3 нуруунаас 161183 ширхэг тарьцыг чацарганы ногоон мөчир тариалсан 20 хүлэмжнээс ухаж гарган тариалалт хийж буй бригадуудад нийлүүлж тариалалт хийлгэсэн. Нийт дүнгээрээ 4-р сард хоёр бригадын 107,1 хүн/өдөр хүч зарцуулан хүлэмжний 1773,5 нуруунаас 301798 ширхэг тарьцыг чацарганы ногоон мөчир тариалсан 20 хүлэмжнээс ухаж гарган тариалалт хийж буй бригадуудад нийлүүлж тариалалт хийлгэсэн.

Мөн 4-р сарын 29 - 30-ны өдрүүдэд Ротаригийн хүлэмжнүүдээс шилмүүст модны үрээр тариалсан тарьцуудыг ухаж авчиран, бойжуулгын талбайд тариалсан ба энэхүү ажилд 1-р бригадын 5 хүн/өдөр хүчээр хүлэмжний 64 нуруунаас 6313 тарьцыг ухаж гарган, 4 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайд 31 хайрцагт 1677 ширхэгийг тариалсан. Мөн 2-р бригадын 5 хүн/өдөр хүчээр хүлэмжний 74,9 нуруунаас 6880 тарьцыг ухаж гарган, 4 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайд 31 хайрцагт 1729 ширхэгийг тариалсан. Бусад 9787 ширхэг шилмүүст модны тарьцыг бусад бригадууд бойжуулгын талбайд тариалсан. Нийт дүнгээрээ хоёр бригадын 10 хүн/өдөр хүчээр Ротаригийн хүлэмжний 138,9 нуруунаас 13193 тарьцыг ухаж гаргаад, нийт бригадуудын нийт хүн хүчээр бойжуулгын талбайд хайрцагт тариалсан.

Мөн 4-р сарын 28 – 30-нд өмнө нь суулгацыг нь гаргасан байсан талбайд дэвсэг үүсгэгч машинаар дэвсэг үүсгэн чацарганы суулгацаар тариалалт хийлгэсэн. Энэ ажилд 3-р бригадын 9 хүн/өдөр хүчээр 19018 суулгацыг, 4-р бригадын 12 хүн/өдөр хүчээр 34848 суулгацыг буюу нийт дүнгээрээ бригадуудын 21 хүн/өдөр хүчээр 53866 ширхэг тарьцыг дэвсэгт тариалж усалгааны бороожуулагч системээр усалсан.

4-р сард ямаа самнах, түлээний мод татах, тракторын араас дагаж хаягдсан суулгац түүх, Ротарийн хүлэмжний үрслэг арчлах зэрэг аж ахуйн ажилд 1-р бригадын 1 хүн/өдөр хүчээр, 2-р бригадын мөн 1 хүн/өдөр хүчээр, 3-р бригадын 29,8 хүн/өдөр хүчээр, 4-р бригадын 1 хүн/өдөр хүчээр буюу нийт дүнгээрээ бригадуудын 32,8 хүн/өдөр хүчээр аж ахуйн ажил хийлгэсэн.

4-р сарын 25 – 30-ны хооронд бойжуулгын талбайн хайрцагт тарьц тариалах ажилд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчийг ашигласан ба энэ ажилд 3-р бригадын 19,6 хүн/өдөр хүчээр 82,98 хайрцагт 43499 ширхэг тарьцыг, 4-р бригадын 24,5 хүн/өдөр хүчээр 114 хайрцагт 60657 ширхэг тарьцыг буюу нийтдээ 44,1 хүн/өдөр хүчээр 196,98 хайрцагт 104156 ширхэг тарьцыг тариалсан. Тарьц тариалсан хайрцаг услах ажилд 1-р бригадын 1 хүн/өдөр хүчээр 31 хайрцагийг, 2-р бригад 1 хүн/өдөр хүчээр 31 хайрцагийг, 3-р бригад 4,4 хүн/өдөр хүчээр 220 хайрцагийг, 4-р бригад 6,5 хүн/өдөр хүчээр 114 хайрцагийг буюу нийтдээ 12,9 хүн/өдөр хүчээр 396 хайрцагийг усалсан.

4-р сард бойжуулгын талбайгаас суулгац ухаж гарган гадагшаа ба дотооддоо нөхөн тариалалтанд нийлүүлэх ажилд 1-р бригадын 1,4 хүн/өдөр хүчээр 597 ш суулгац, 2-р бригадын 1 хүн/өдөр хүчээр 410 ш суулгац буюу нийтдээ 2,4 хүн/өдөр хүч зарцуулан 1007 ш суулгацыг ухаж гарган нөхөн тариалалтанд нийлүүлсэн.

5-р сард жимст цэцэрлэгийн талбайн хог цэвэрлэх, тогооч хийх, хөлдөөх камеруудыг угааж цэвэрлэх, жимс хийдэг 120 л-ийн савнуудыг угааж цэвэрлэх, бордоо ачиж, буулгах, компаний малд урьдчилан сэргийлэх тарилга хийлгэх, үрийн буудайгаар үрлэгч машин цэнэглэх зэрэг аж ахуйн ажилд 1-р бригадын 24 хүн/өдөр, 2-р бригадын 15,2 хүн/өдөр, 3-р бригадын 21 хүн/өдөр, 4-р бригадын 13 хүн/өдөр буюу нийтдээ 72,2 хүн/өдөр хүч зарцуулсан.

5-р сард жимст цэцэрлэгийн чацарганы модонд тоос хүртээх, жимст цэцэрлэгийн чацарганы модонд тоос хүртээхэд зориулж хөгширч актлагдсан эр модны суулгацаас тоос хүртээх

мөчир хайчлан тоос хүртээлт хийж буй бригадуудад нийлүүлэх, үхэр нүдний талбайн хярууны хамгаалалтанд бэлтгэх, хярууны хамгаалалтанд гарах, хавар шинээр тариалсан алим, чавганы суулгацын усалгааны усанд идэгдсэн тогоог засах, гадагш нийлүүлэх суулгацыг түр хадгалалтаас ухаж гарган ялган тоолж ангилаад, шошго зүүн боож ачих, орсон олон төрлийн модны хучлага авах, гүзээлзгэний арчилгаа, усалгаа, олон төрлийн модны тогооны сийрүүлэлт хийх, талбайн шижмийн хогийг бөөгнүүлэн тракторт ачих, шинээр хагалж бойжуулгад бэлтгэсэн талбайгаас чацарганы шижим түүх, тракторт чиг татаж зогсох, ТУР-ын конторын хашаанд жимсний мод тариалах, Ротарийн хүлэмжинд хүлэмж хучих, хэмх тариалах хүлэмжүүдэд хэмх тариалах хамар хийх, ус халааж дарлага услах, дарлаганы зэрлэг авч салхилуулан арчилгаа хийх, хүлэмжний засвар үйлчилгээ хийх, мотор систем угсрах, хүлэмж хучих, хүлэмжний усалгаа хийх зэрэг цагийн ажилд 1-р бригадын 40,9 хүн/өдөр хүч, 2-р бригадын 128,9 хүн/өдөр хүч, 3-р бригадын 88 хүн/өдөр хүч, 4-р бригадын 25 хүн/өдөр хүч буюу нийт дүнгээрээ 282,8 хүн/өдөр хүч зарцуулсан.

5-р сард 1-р бригадын 1 хүн/өдөр хүчээр 170 м урт усалгааны шуудууг гараар ухуулж, засуулаад, 211,8 хүн/өдөр хүчээр нөхөн тариалсан болон нөхөн тариалалт хийгдээгүй талбайд 311120 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн. 2-р бригадын 50,6 хүн/өдөр хүчээр нөхөн тариалсан болон нөхөн тариалалт хийгдээгүй эх цэцэрлэгийн талбайд 64500 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн. 3-р бригадын 106 хүн/өдөр хүчээр нөхөн тариалсан болон нөхөн тариалалт хийгдээгүй талбайд 155250 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн. 4-р бригадын 222,8 хүн/өдөр хүчээр нөхөн тариалсан болон нөхөн тариалалт хийгдээгүй талбайд 241170 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн.

5-р сард Ротаригийн шилмүүст мод тариалсан хүлэмжүүдээс шилмүүст модны үрээр тариалсан тарьц гараар ухаж гаргах ажилд 1-р бригадын 4,5 хүн/өдөр хүч зарцуулан хүлэмжний 18 нуруунаас 788 ширхэг тарьцыг, 2-р бригадын 1 хүн/өдөр хүч зарцуулан хүлэмжний 14 нуруунаас 1470 ширхэг тарьцыг буюу нийт дүнгээрээ 5,5 хүн/өдөр хүч зарцуулан хүлэмжний 32 нуруунаас 2258 ширхэг шинэс, гацуур, нарсны үрээр тариалсан тарьцыг ухаж гарган тариалалт хийж буй бригадуудад нийлүүлж тариалалт хийлгэсэн.

5-р сард бойжуулгын талбайн хайрцагт тарьц тариалах ажилд 2-р бригадын 2 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайн 4 хайрцагт 1470 ширхэг шилмүүст модны тарьцыг, 3-р бригадын 4 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайн 4 хайрцагт 1479 ширхэг шилмүүст модны тарьцыг, 4-р бригадын 6 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайн 10 хайрцагт 2827 ширхэг шилмүүст модны тарьцыг буюу нийтдээ 12 хүн/өдөр хүчээр 18 хайрцагт 5776 ширхэг тарьцыг тариалсан. Шинээр тарьц тариалсан хайрцагны эхний болон давтан усалгаа хийх ажилд 2-р бригадын 58,4 хүн/өдөр хүчээр 3893 хайрцагийг, 3-р бригадын 2,4 хүн/өдөр хүчээр 40 хайрцагийг буюу нийтдээ 60,8 хүн/өдөр хүчээр 3933 хайрцагийг усалсан.

5-р сард 1-р бригадын 9,5 хүн/өдөр хүн хүчээр нөхөн тариалж, арчилгаа хийж буй талбайд 1193 ширхэг чацарганы мод нөхөн тариалах нүх ухаж, 3,25 хүн/өдөр хүн хүчээр 327 суулгацаар нөхөн тариалалт хийсэн. 2-р бригадын 3 хүн/өдөр хүн хүчээр нөхөн тариалж, арчилгаа хийж буй талбайд 480 ширхэг чацарганы мод нөхөн тариалах нүх ухаж, 4 хүн/өдөр хүн хүчээр 464 суулгацаар эх цэцэрлэгийн талбайд нөхөн тариалалт хийсэн. 3-р бригадын

3 хүн/өдөр хүн хүчээр нөхөн тариалж, арчилгаа хийж буй талбайд 1115 ширхэг чацарганы мод нөхөн тариалах нүх ухаж, 2 хүн/өдөр хүн хүчээр 1115 суулгацаар жимст цэцэрлэгийн талбайдаа нөхөн тариалалт хийсэн. 4-р бригадын 1 хүн/өдөр хүн хүчээр нөхөн тариалж, арчилгаа хийж буй талбайд 545 ширхэг чацарганы мод нөхөн тариалах нүх ухаж, 5 хүн/өдөр хүчээр 892 суулгацаар жимст цэцэрлэгийн талбайдаа нөхөн тариалалт хийсэн.

5-р сард 2-р бригадын 14,8 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайн 48 хайрцагнаас нөхөн тариалалт хийх 12741 суулгацыг, 3-р бригадын 6 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайн 12 хайрцагнаас нөхөн тариалалт хийх 3381 суулгацыг буюу нийт дүнгээрээ 54 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайн 60 хайрцагнаас гадагш нийлүүлэх болон дотооддоо нөхөн тариалалт хийх 16122 суулгацыг ухуулж гаргуулсан.

5-р сард чацарганы модны эргэн тойронд ургасан зэрлэгийг устгах ажилд 1-р бригадын 1,5 хүн/өдөр хүчээр 950 м урт мод тариалсан шуудууны 1-р зэрлэгийг авахуулсан.

5-р сард бойжуулгын 2-р бригадын 41,8 хүн/өдөр хүчээр өмнөх жилийн ба энэ жилийн суулгац тариалсан 1354 хайрцагны доторх гүн сийрүүлэлтийг хийлгэсэн. Мөн тус бригадын 22,8 хүн/өдөр хүчээр 608 хайрцагны зэрлэг хог ургамлыг гараар зулгааж авах ажилбар хийлгэсэн.

5-р сард оросын олон төрлийн жимсний моддыг хувингаар тогоонд нь услах ажилд бойжуулгын 2-р бригадын 6,3 хүн/өдөр хүчээр 3197 модыг усалсан.

Мөн 5-р сард ХААЯ-ны ТЭДС-гаас энэ хавар авсан “Алтайское Румянное” сортын бэсрэг алимны 100 ширхэг, “Чемальская синяя”, “Жёлтая хопта” гэсэн хоёр сортын чавганы 496 ширхэг суулгацуудыг 10Б талбайд шинээр талбай бэлтгээд 2-р бригадын цэцэрлэгчидээр тариулсан. Энэхүү ажилд тус бригадын 6,4 хүн/өдөр хүчээр тариалалт хийх 596 нүх ухуулж, 3,5 хүн/өдөр хүчээр тариулж, 1 хүн/өдөр хүчээр таналт хийлгэж, 3,4 хүн/өдөр хүчээр шуудуунаас хувингаар тогоо уруу нь ус хийлгэж услуулаад, мөн 1 хүн/өдөр хүчээр тариалсан модны тогооны сийрүүлэлт хийлгэсэн.

6-р сард 1-р бригадын 98,5 хүн/өдөр хүчээр 159350 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн. 2-р бригадын 40,8 хүн/өдөр хүчээр 68950 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн. 3-р бригадын 19 хүн/өдөр хүчээр 43700 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн. 4-р бригадын 84 хүн/өдөр хүчээр 134750 м урт усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн.

6-р сард Ротарийн хүлэмжинд хэмхний нөхөн тариалалт хийх, Ротаригийн ба урд хүлэмж хучих, хүлэмжний хар тор нөхөх, хүлэмжийг хар тороор хучих, хүлэмжинд засвар үйлчилгээ хийх, хүлэмжинд гүзээлзгэний усалгааг цагийн графикаар хийх, хүлэмжний гүзээлзгэний зэрлэгийг гараар авах, шилмүүст модны нүх ухах, усалгааны дараа үндэс нь усалгааны усанд идэгдэж ил гарсан нөхөн тариалалтын суулгацын үндсийг буцаан булж засах, дарлаганы хучлага авах, дарлага услах, дарлаганы зэрлэг гараар авах, затурын шороог чайна-д хийж кранаар гарган асгах зэрэг цагийн ажилд 1-р бригадын 20,7 хүн/өдөр хүч, 2-р бригадын 50 хүн/өдөр хүч, 3-р бригадын 69,7 хүн/өдөр хүч, 4-р бригадын 16 хүн/өдөр хүч буюу нийт дүнгээрээ 156,4 хүн/өдөр хүч зарцуулсан.

6-р сард жимст цэцэрлэгийн талбайн чацаргана тариалсан мөрөнд ургасан өмнөх жилийн шижмийг устгах ажилд зарим бригадуудын хүн хүчийг ашигласан. Үүнд: 1-р бригадын 13,8 хүн/өдөр хүчээр 1150 м урт шуудууны, 4-р бригадын 6,1 хүн/өдөр хүчээр 1030 м урт шуудууны буюу нийт дүнгээрээ 19,9 хүн/өдөр хүчээр 2180 м урт шуудууны шижмийг цавчуураар авахуулж устгуулсан.

6-р сард үхэр нүдний 9 га-ийн талбайд нөхөн тариалалт ихтэй 1 га орчим талбайн үхэр нүдний суулгацуудыг нь бусад талбайд нь шилжүүлэн нөхөн тариулаад, суларсан талбайд нь бөөрөлзгөний суулгацыг тариалсан. Энэ ажилд 1-р бригадын 1 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөний 480 суулгацыг, 2-р бригадын 2,4 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөний 1380 суулгацыг буюу нийт дүнгээрээ 3,4 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөний 1860 суулгацыг оросын олон төрлийн модны эх цэцэрлэгийн талбайгаас хүрзээр ухуулж, 1-р бригадын 4,1 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөнө тариалах 875 нүх, 4-р бригадын 2,4 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөнө тариалах 525 нүх буюу нийтдээ 6,5 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөнө тариалах 1400 нүх ухуулж бэлтгээд, 1-р бригадын 4,1 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөнө тариалах 875 суулгацыг, 4-р бригадын 3,6 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөнө тариалах 525 суулгацыг тус тус тариалуулаад 1-р -р бригадын 2,6 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөнө тариалсан нийт талбайн 6000 м урт шуудуугаар услуулан.

6-р сард 2-р бригадын 2,4 хүн/өдөр хүчээр бөөрөлзгөний 1380 суулгацыг шинээр хайрцаг бэлтгээд түүндээ тариалж, усалгаа хийлгэсэн. Мөн 5,8 хүн/өдөр хүчээр оросын олон төрлийн 4308 модны талбайд хөрс сийрүүлэх арчилгааг хийлгээд, 10,4 хүн/өдөр хүчээр мөн тус талбайд 4915 модны тогоонд хувингаар ус хийлгэн усалгаа хийлгэсэн.

Мөн 6-р сард тус 2-р бригадын 1,5 хүн/өдөр хүчээр 37 мөрний усалгааны систем бүхий талбайн зэрлэг хог ургамлын гараар зулгааж устгах ажилбарыг, 1,5 хүн/өдөр хүчээр 37 мөр бойжуулгын талбайн 180 м² хэмжээтэй дэвсэгийн талбайд мөр хоорондын сийрүүлэлт хийлгэх зэрэг ажлуудыг хийлгэсэн.

6-р сард бойжуулгын талбай хариуцсан 2-р бригадын 62 хүн/өдөр хүчээр 2088 хайрцагны гүн сийрүүлэлтийн ажилбар, 11,7 хүн/өдөр хүчээр 347 хайрцагны хамар шуудууны зэрлэгийг гараар зулгааж авах ажилбар, 37,2 хүн/өдөр хүчээр 815 хайрцагны доторх мөр хоорондын зэрлэгийг гараар зулгааж аван устгах ажилбар, 29,6 хүн/өдөр хүчээр суулгац тариалсан 2531 хайрцгийг услуулах ажилбаруудыг тус тус хийлгэсэн.

6-р сард 1-р бригадын 1,1 хүн/өдөр хүчээр 20 м³ хэмжээтэй хүлэмжний хайргыг, 2-р бригадын 1,4 хүн/өдөр хүчээр 13,2 м³ хэмжээтэй хүлэмжний хайргыг, 3-р бригадын 5 хүн/өдөр хүчээр 6 м³ хэмжээтэй хүлэмжний хайргыг буюу нийт дүнгээрээ 7,5 хүн/өдөр хүчээр ногоон мөчир тариалах хүлэмжний 39,2 м³ хэмжээтэй хайргыг тэгшлүүлж дэвсүүлсэн. Мөн 1-р бригадын 6,6 хүн/өдөр хүчээр 55,9 м³ хэмжээтэй хүлэмжний хар шороог, 2-р бригадын 9,6 хүн/өдөр хүчээр 44,4 м³ хэмжээтэй хүлэмжний хар шороог, 3-р бригадын 3,5 хүн/өдөр хүчээр 11,2 м³ хэмжээтэй хүлэмжний хар шороог, 4-р бригадын 5,6 хүн/өдөр хүчээр 22,47 м³ хэмжээтэй хүлэмжний хар шороог буюу нийт дүнгээрээ 25,3 хүн/өдөр хүчээр 133,97 м³ хэмжээтэй хүлэмжний шигшсэн хар шороог тэгшлэн тараасан.

6-р сард жимслэгч ба эх цэцэрлэгийн мод тариалсан шуудууны зэрлэгийг гараар ба гар багажаар аван устгах ажилд бригадуудын хүн хүчийг дараах байдлаар хуваарилж оруулсан. Үүнд: 1-р бригадын 23,7 хүн/өдөр хүчээр 11550 м урт мод тариалсан шуудууны, 3-р бригадын 66 хүн/өдөр хүчээр 41200 м урт мод тариалсан шуудууны, 4-р бригадын 15,2 хүн/өдөр хүчээр 8500 м урт мод тариалсан шуудууны буюу нийт дүнгээрээ 104,9 хүн/өдөр хүчээр 61250 м урт мод тариалсан шуудууны зэрлэгийг авахуулсан.

7-р сард хүлэмжий тарилтууд хийгдэж дууссан. Мөн гүзээлзгэнэ бөөрөлзгөнө зэрэг жимсний хураалт хийгдэж дууссан.

8-р сарын сүүл үеэс эхлэн 10-р сарын 20 хүртэл чацаргана жимсний хураалт хийгдсэн. 10-р сард чацаргана болон бусад жимсний суулгац гаргаж борлуулсан. 11, 12 сард техникийг өвлийн тэг зогсолтонд тавьж байршуулсан.

11. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр:

“Хархорин” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2018 оны 04-р сарын 18-ны өдөр Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах өөрийн байранд, хурлын танхимд хуралдуулсан.

Тус хурлыг зарлан хуралдуулах асуудлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2018 оны 03-р сарын 07-ны өдрийн хурлаараа авч хэлэлцээд холбогдох шийдвэрийг гаргасан. Хурлын мэдэгдлийг 2018 оны 03-р сарын 09-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

Тус ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-с бүртгэлийн өдрөөр гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг гаргуулан авсан болно.

Тус судалгааны дагуу тус бүр нэг саналын эрх бүхий нийт 539,515 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 576 хувьцаа эзэмшигчид 2018 оны 04-р сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй байсан. Эдгээр хувьцаа эзэмшигчдээс нийт 378,046 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нийт 5 хувьцаа эзэмшигч тус хуралд биечлэн оролцож саналаа өгсөн болно. Хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигч гараагүй.

Хурлын ирц 70.07 хувь болсон.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд болон эдгээр асуудал тус бүрээр хуралд оролцсон саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын тоог, хувь зэргийг дараах хүснэгтээс үзнэ үү:

Д/д	Хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2017 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	378,046 (100%)	0	0
2	Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	378,046 (100%)	0	0
3	Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг батлах	378,046 (100%)	0	0
4	Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	378,046 (100%)	0	0

Жич: хүчингүй саналын хуудас гараагүй болно.

“Хархорин” ХК-ийн 2018 оны 04-р сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолуудтай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас үзэж танилцах боломжтой.

Тус хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг 2018 оны 04-р сарын 20-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

12. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл болон тус зөвлөлөөс гаргасан шийдвэрүүдийн тухай

2018 онд «Хархорин» ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт гараагүй болно. 2018 онд “Хархорин” ХК-ийн ТУЗ-с дараах шийдвэрүүдийг гаргасан:

Тогтоол, шийдвэрийн Огноо	Товч утга	Тогтоол шийдвэрийн агуулга
2018.02.14	Ногдол ашиг хуваарилахгүй тухай	ТУЗ-с Компанийн тухай хуульд заасны дагуу ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг хэлэлцээд 2017 онд ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан.
2018.03.07	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 04-р сарын 18-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэж хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталсан.
2018.03.21	Батлан даалт гаргах, хөрөнгө барьцаалах, гарын үсэг зурах эрх олгох тухай	Хархорин чацаргана ХХК-ийн зээлд батлан даалт гаргаж УБ хотын банкинд барьцаалсан байгаа хөрөнгөнүүдийг давхар барьцаалахаар шийдвэрлэв.

2018.04.17	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргыг шинээр томилох тухай	Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04-р сарын 18-ны өдрийн ээлжит хурлыг даргаар томилогдоод байсан П.Бишрэл нь тус хурлыг даргалах боломжгүй болсон тул Б.Амарсанааг хурлын даргаар томилсон.
------------	--	---

13. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

“Хархорин” ХК-ийн 5% ба үүнээс илүү хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд тайлант хугацаанд буюу 2018 онд дараах өөрчлөлт гарсан:

Хувьцаа эзэмшигч Л.Хосбаяр нь өөрийн эзэмшиж байсан 101,634 ш энгийн хувьцаа буюу “Хархорин” ХК-ийн 18.84%-г 2018 оны 09-р сард “Селус Номадс” ХХК нэртэй Монгол Улсын хуулийн этгээдэд шилжүүлсэн. Энэ тухай тус компаниас албан бичгээр “Хархорин” ХК-д мэдэгдсэн болно.

5% ба үүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн дараах байдалтай байна:

Д.д	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, хувь
1	С.Пүрэв	377,660 (70.00%)
2	Селус Номадс ХХК	101,634 (18.84%)

“Хархорин” ХК, 2019 он